




АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- ☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Хот байгуулалт, хөгжлийн газар

Нэгжийн нэр:

Барилга байгууламжийн чанарын хэлтэс

Албан тушаалын нэр:

Барилга байгууламжийн чанарын
хэлтсийн дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-9

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо, Наадамчдын
зам 1200, Арцатын ам, Нийслэлийн төр
захиргааны цогцолбор байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хот байгуулалтын салбарын бодлого, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, барилга, байгууламжид мэргэжлийн дүгнэлт гаргах, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих, чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.



АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

- ☒ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан
шинэчлэн боловсруулсан
- ☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Хот байгуулалт, хөгжлийн газар

Нэгжийн нэр:

Барилга байгууламжийн чанарын хэлтэс

Албан тушаалын нэр:

Барилга байгууламжийн чанарын
хэлтсийн дарга

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Ахлах түшмэл, ТЗ-9

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо, Наадамчдын
зам 1200, Арцатын ам, Нийслэлийн төр
захиргааны цогцолбор байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хот байгуулалтын салбарын бодлого, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, барилга, байгууламжид мэргэжлийн дүгнэлт гаргах, аюулгүй байдлыг хангах, хяналт тавих, чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

<u>Албан тушаалын зорилт:</u> 1.Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах, мэдээллээр хангах. 2.Барилга, байгууламжид мэргэжлийн дүгнэлт гаргах, аюулгүй байдлыг хангах, холбогдох шийдвэр гаргуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих. 3.Гамшгийн үеийн төлөвлөлт хийж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах. 4.Нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.			
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон бусад байгууллагыг шаардлагатай тайлан, мэдээ, мэдээллээр хангах;	Тайлан мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргасан байна.	Г
	2.Холбогдох хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үнэлгээ өгөх, санал, зөвлөмж боловсруулж, танилцуулах;	Зохих журмын дагуу гүйцэтгэж, үр дүнг танилцуулсан байна.	Г, Х
	3.Барилга байгууламжийн чанар аюулгүй байдалтай холбоотой асуудлыг хэлэлцэхэд оролцож эрх хэмжээнийхээ асуудлаар санал тавьж шийдвэрлүүлэх;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Г, Х, Ш
	4.Нийслэлийн орон тооны бус паспортжуулалтын зөвлөлийн хурлын бэлтгэл, бэлэн байдал болон үйл ажиллагааг тасралтгүй хангах.	Зөвлөлийн үйл ажиллагааг журамд нийцсэн байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Барилга, байгууламжийн чанарт үзлэг, хэмжилт хийх, насжилтын судалгаа явуулах, хэрэгжилтийг хянах;	Хэмжилт, судалгаа, үнэн, зөв бодит, байна.	Г, Х
	2.Барилга байгууламжийн чанар, бат бэх, найдваржилтын төлөв байдал, мэргэжлийн дүгнэлт гаргаж паспортжуулах, хяналт тавих, үр дүнг хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэх;	Дүгнэлт нь бодитой, норм, дүрэмд нийцсэн, мэдээллийн сангийн баяжилт хийгдсэн байна.	Г, Х



	3.Болзошгүй газар хөдлөлтөд тэсвэргүй, эрсдэлтэй барилга байгууламжийг буулгах, зориулалтыг өөрчлөх, хүчитгэл бэхэлгээ хийх, норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх, зөвлөмж гаргах;	Барилга байгууламжийн ашиглалтын байдал норм, нормативт хэмжээнд хүрсэн байна.	Г, Х
	4.Барилга байгууламжийн чанар, аюулгүй байдлыг хангах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллах.	Барилга байгууламжийн чанар, аюулгүй байдал хангагдсан байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Гамшгаас хамгаалах албаны төлөвлөгөө боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тайлагнах;	Гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдал дээшилсэн байна.	Г, Х
	2.Гамшгаас хамгаалах орон нутгийн албатай хамтарч ажиллах, сургалт, хурал, зөвлөгөөнд оролцох, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах.	Гамшигтай тэмцэх чадавх, хамтын ажиллагааг дээшлүүлсэн байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, дүгнэх, тайлагнах;	Зохих журмын дагуу хянаж, тайлагнасан байна.	Г, Х
	2.Нэгжийн албан хаагчдын цалин хөлс, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, албан тушаалын ангилал, зэрэглэл, зэрэг дэв, нийгэм, ахуйн хөнгөлөлт, шагнал урамшуулал, хариуцлага тооцуулах асуудлаар санал боловсруулах, танилцуулах;	Нэгжийн хамт олны саналыг сонсож, оролцоог хангасан байна.	Г, Х
	3.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, тайлан мэдээний чанарт анхаарч хяналт тавих, танилцуулах;	Тайлан мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргасан байна.	Г, Х
	4.Төрийн албаны стандартыг хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин, газрын дотоод журмыг мөрдөн ажиллах;	Холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажилласан байна.	Г, Х
	5.Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, албан бичгийг судлан хугацаанд нь чанартай шийдвэрлэх, гүйцэтгэлд хяналт тавих;	Зохих журмын дагуу зохион байгуулж, хянаж, тайлагнасан байна.	Г, Х, Ш

	6.Архив, албан хэрэг хөтлөлтийн холбогдох хууль журмыг мөрдөн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу үүссэн баримт бичгийг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөх, хяналт тавих;	Зохих журмын дагуу зохион байгуулж, хянаж тайлагнасан байна.	Г, Х
	7.Нэгжийн албан хаагчдад мэдээллийг шуурхай хүргэх, бусад нэгжтэй мэдээлэл солилцох ажлыг зохион байгуулах, хяналт тавих;	Мэдээлэл нь судалгаа, нотолгоотой бодитой байна.	Г, Х, Ш
	8.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.	Хууль тогтоомжид заасан чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.	
Мэргэжил	- Барилгын инженер. - иргэний ба үйлдвэрийн барилга, байгууламж /073204, 073206, 073208, 073209/.	
Мэргэшил	Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Төрийн албанд 8-с доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 4-с доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	- нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, зарчимч шаардлага тавих; - албан хаагчдын ажил үүргийг оновчтой хуваарилах; - албан хаагчдын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, зохих заавар чиглэл өгөх; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргах; - асуудлыг хууль журам, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - аливаа асуудлыг шийдвэрлэхдээ хамт олны саналыг харгалзан үздэг байх; - албан хаагчдын саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Дүн шинжилгээ хийх	- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл боловсруулах, харьцуулалт хийх, нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - судалгааны ерөнхий арга зүйн мэдлэгтэй байх; - мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн шинжилгээ хийх; - судалгааны дүн, мэдээлэлд тулгуурлан бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж, боловсруулах; - шийдвэрийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарыг боловсруулах; - бусад.

	Асуудал шийдвэрлэх	- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд үнэнчээр зүтгэх; - тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хувилбарыг боловсруулж түүний зэрэг, сөрөг үр дагаврыг тодорхойлох; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэр гаргах; - асуудлыг хууль журам, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах; - аливаа асуудлыг шийдвэрлэхдээ хамт олны саналыг харгалзан үздэг байх; - бусад.
	Манлайлах	- ёс зүйгээр хамт олныг үлгэрлэн манлайлах; - шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх; - итгэлцлийг бий болгох, албан хаагчдад адил тэгш хандах, зөв шударгаар дүгнэх; - шинэ санаа, бүтээлч хандлагыг дэмжих; - зарчимч, ажил хэрэгч чанараар хамт олныг үлгэрлэх; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтаар хамт олныг манлайлах; - бусад.
	Бусад	- барилга угсралтын болон бүтээцийн зураг төслийн чиглэлээр мэргэшсэн байх; - AutoCAD, ArcGIS программ дээр ажиллах чадвартай байх; - газар хөдлөлийн инженерийн программ дээр тооцоо хийх чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт техник, технологи ашиглах; - багаар ажиллах, амжилтыг дэмжиж бусдад таниулах; - байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

ахлах мэргэжилтэн: 1.
мэргэжилтэн – 6.
Нийт: 7

Бусад харилцах субъект:

- яам, агентлагийн холбогдох албан тушаалтан;
- нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох албан тушаалтан;
- төрийн болон төрийн бус байгууллага;
- иргэн, хуулийн этгээд.

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг
боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж,
батлах зөвшөөрөл олгосон
байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ОРЛОГЧ ДАРГА

..... /Ч.БУМ-ЭРДЭНЭ/
(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)

2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо: 22 05 11

Дугаар: 331

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

Байгууллагын нэр:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо: 2022.05.20

Дугаар: 331

(тамга/тэмдэг)

ДАРГА

(Гарын үсэг)

/Ц.ТУЛГА/

(Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр)

2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр

